



Шинжээчийн багийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Интерьер дизайн

Хөтөлбөрийн индекс: D021204

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Сэрээтэрдорж (МУБИС-ийн Дүрслэх урлаг
технологийн сургууль, Технологийн тэнхим)

Гишүүд: Х.Лутчимэг (ИЗОУИС-ийн Чанарын баталгаажилтын албаны дарга
доктор (Ph.D), дэд профессор

Д.Отгонцэцэг (Олон улсын Улаанбаатарын Их Сургуулийн Дизайны
тэнхимийн ахлах багш)

АГУУЛГА	3
Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	4
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	16
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	21
Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн	25
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	28
IV. Уулзалтад оролцогчдын бүртгэл	
1. Багш нарын нэрс	33
2. Оюутнуудын нэрс	33
3. Ажил олгогчдын нэрс	35
4.Төгсөгчдийн нэрс	36
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	37
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	38
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	38

Товчилсон үгийн тайлбар

БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БМИУЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
ШУТ сан	Шинжлэх Ухаан Технологийн сан
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ҮТС	Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль
CDIO	Зохиох бүтээх хөгжүүлэх хэрэглэх
PEOs	Program Educational Objectives-Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
PLOs	Program Learning Outcomes- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
CLOs	Course Learning Outcomes-Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
ҮДСБ	Үр Дүнд Суурилсан Боловсрол
ЭЭШ	Элсэлтийн Ерөнхий Шалгалт
ЭША	Эрдэм Шинжилгээний Ажил
ЭШХ	Эрдэм Шинжилгээний Хурал
ОЗ	Оюутны Зөвлөл

ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Интерьер дизайн
Индекс	021204 бакалавр

<p>Шинжээчид</p>	<p>Багийн ахлагч:</p> <p>Овог нэр: Дүгэррагчаа СЭРЭЭТЭРДОРЖ Ажил албан тушаал: Тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор Ажлын газар: МУБИС-ийн Дүрслэх урлаг технологийн сургууль, Технологийн тэнхим</p> <p>Гишүүд:</p> <p>1. Овог нэр: Х.ЛУТЧИМЭГ Ажил албан тушаал: ИЗОУИС-ийн Чанарын баталгаажилтын албаны дарга доктор (Ph.D), дэд профессор Ажлын газар: Их Засаг Олон Улсын Их Сургууль</p> <p>2. Овог нэр: Д.ОТГОНЦЭЦЭГ Ажил албан тушаал: Олон улсын Улаанбаатарын Их Сургуулийн Дизайны тэнхимийн ахлах багш Ажлын газар: Олон улсын Улаанбаатарын Их Сургууль</p>	
<p>БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн</p>	<p>Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг</p>	
<p>Төлөвлөгөө</p>	<p>2023.05.01</p>	<p>Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх</p>
<p></p>	<p>2023.05.05</p>	<p>Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх</p>
<p></p>	<p>2023.01.16</p>	<p>Сургуулийн бэлэн байдлыг нягтлах</p>
<p></p>	<p>2023.05.10-11</p>	<p>Шинжээчид сургууль дээр ажиллах</p>
<p></p>	<p>2023.05.18</p>	<p>Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх</p>
<p></p>	<p></p>	<p>Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх</p>
<p></p>	<p></p>	<p>Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох</p>
<p></p>	<p></p>	<p>Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах</p>
<p>Шалгуур шаардлага</p>	<p>БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.</p>	

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн дизайны сургууль нь анх 1994-1995 оны хичээлийн жилд БИС-ийн дэргэд тэнхим нэртэйгээр суурь нь тавигдаж, 1998 оноос бие даасан тэнхимээс сургууль болон өргөжиж бакалавр зэрэгтэй дизайнер мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн байна. Өнөөдрийг хүртэл тасралтгүй сургалт явуулж ирэхдээ улс орны хөгжлийн эрэлтэд нийцүүлэн 22 төрлийн мэргэжилтэн бэлтгэж байгаагаас “Интерьер дизайн” мэргэжлийн бакалаврын сургалтын төлөвлөгөө 5 дахь удаагаа шинэчлэгдэн боловсруулагдсан байна. Тус хөтөлбөр нь 2015 оноос инженерийн зохион бүтээлтэд суурилсан CDIO олон улсын арга зүйг сургалтдаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Интерьер дизайн хөтөлбөрийн зорилгыг ШУТИС 2030 стратеги төлөвлөлт, Алсын хараа: “дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ” хэмээх эрхэм зорилготой уялдуулан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд “Интерьер дизайны үндсэн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, “судалгаа- шинэ санаа-загварчлал-гүйцэтгэл” системийн дагуу төслийн ажлыг бие даан гүйцэтгэдэг, хариуцлагатай, бүтээлч сэтгэлгээтэй, байнга өсөн дэвжих мэргэжилтэн бэлтгэнэ” гэж томъёолсон байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг томъёолохдоо олон улсын CDIO үзэл баримтлалын хоёрдугаар түвшний үр дүнгийн жагсаалт, ABET-ийн сургалтын үр дүнгүүдийн хамаарлыг тодорхойлсны үндсэн дээр 4 бүлэг, 17 зүйлээр оновчтой томъёолсон.

Хөтөлбөрийн зорилтуудыг 4 хэсгээр, сургалтын зорилтуудтай уялдуулан дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

1. Дизайны мэдлэг ур чадвар
2. Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил
3. Нийгмийн харилцааны чадвар (багаар ажиллах чадвар ба харилцаа)
4. CDIO ур чадвар

Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг тодорхойлохдоо: CDIO арга зүйн дагуу шинээр элсэгчдийн дүр төрх, хүсэл сонирхлыг тодорхойлсны үндсэн дээр тэдний санааг тусган, мэргэжилтний дизайнчлан төлөвлөж, хэрэгжүүлэх шатыг дамжин, хөтөлбөрөөр хүрэх үр дүнтэй уялдуулан, төгсөгчийн ирээдүйд хүрэх үр дүнг загварчлан зурж төлөвлөдөг онцлогтой.

Сургалтын төлөвлөгөөний бүтцийг нийт 5 удаа шинэчилсэн, “Интерьер дизайн” нэршлээр сургалтын төлөвлөгөөг 3 дахь удаагийн шинэчлэл хийгдэж, 2022 оны 05 сарын 09-ний өдрийн А/160 тоот тушаалыг баримталж сургалтын хөтөлбөрийн индекс, ангилалд тавигдах шаардлагын дагуу боловсруулж, суралцагчид нь сургалтын нэгдсэн төлөвлөгөөгөөр нийт 128 кредит цаг судлах, ерөнхий ба суурь шинжлэх ухааны хичээл 29.68 хувь буюу 30 хувиас хэтрэхгүй тохиромжтой, мэргэжлийн суурь хичээл 29.68 хувь буюу 25 хувиас хэтрэхгүй байхаас 4.68 хувиар илүү төлөвлөгдсөн, мэргэжлийн хичээл 35.15 хувь буюу 45 хувиас багагүй байх шаардлагаас дутуу төлөвлөгдсөн байна.

Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж: Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичигтэй, хэрэгжилтийн тайланг тогтмол гаргадаг. Доктор зэрэгтэй

багш нарын эзлэх хувийн жин, судалгааг сүүлийн 5 жилээр гаргасан бөгөөд одоо нийт багш нарын 30 хувь нь докторын зэрэгтэй, багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгааг сүүлийн 5 жилээр гарсан байна. Интерьер дизайн хөтөлбөрийн профессор, багш нарын А кредит цагийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлийг ачааллаас харахад нийт багш нарын гүйцэтгэсэн ачаалал хангалттай буюу мэргэжлийн багш нарын ачаалал үндсэн ачааллаас давсан үзүүлэлттэй байна. (тайлан 119-р хуудас) Багшийн албан тушаалын зэрэглэлийн, гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн байдлын, цагийн ачааллын, урамшууллын судалгаанд тулгуурлан хүний нөөцийн бодлоготой ажилладаг.

ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам (2023-2024 оны хичээлийн жил) ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/110 дугаар тушаалыг мөрдлөг болгон элсэлт авдаг бөгөөд элсэгч, төгсөгчийн харьцаа сүүлийн 5 жилээр 2017 онд 53/39, 2018 онд 66/42, 2019 онд 68/40, 2020 онд 65/46, 2021 онд 61/49, тус хөтөлбөрөөр 2022 онд 63 оюутан суралцаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Монгол улсын дээд боловсролын стандарт MNS 5323-120:2011 ыг баримталдаг, 2020.03.02-ны өдрийн дугаар 960009 тоот тусгай зөвшөөрөлтэй. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө УБ. 2020 баримтлан, БШУ-ны сайдын 2022.05.03 ны өдрийн А/160 тоот тушаалаар батлагдсан индексийн дагуу хөтөлбөрөө шинэчилсэн
- ✓ Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо өөрсдийн 30 жилийн туршлагадаа тулгуурлан, гадаад болон дотоодын Интерьер дизайны үйлчилгээний зах зээлийн урьдчилсан судалгааг харьцуулан авч үзсэн, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээний талаарх өнөөгийн байдлын судалгааг хийж эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагыг олж тогтоосон байна.
- ✓ Интерьер дизайны мэргэжил нь зөвхөн дотоодын зах зээлээр хязгаарлагдахгүй гэж үзэж, тус хөтөлбөрөөр суралцагчид болон, ирээдүйн төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар хандлагыг тогтоох зорилгоор STEEP шинжилгээ хийсэн.
- ✓ Гадаадын 4 сургууль, дотоодын 1 сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөө, ерөнхий агуулгын харьцуулалт хийж, хөтөлбөрөө сайжруулсан.
- ✓ Сургалтын хөтөлбөрийн судалгаа хөгжүүлэлтийг Суралцахуйн үр дүн-Заах арга зүй-Үнэлгээ гэсэн гурвал хамааралтайгаар авч үздэг,

- ✓ Мэргэжлийн хэлэлцүүлгийг тогтмол өрнүүлж, ялгарах онцлогуудаа тодруулж, Design thinking аргачлалын дагуу сууриа тавих шийдэлд хүрсэн
- ✓ Хөтөлбөрийн шинэчлэлийг бакалавр, магистр, докторын түвшний судалгааны чиглэл болгосон

Онцлог зүйл: Үр дүнд суурилсан боловсролын хэлбэр болох инженерийн зохион бүтээлтийн төслийн чиглэлтэй CDIO арга зүйн тогтолцоог 2015 оноос эхлэн хэрэгжүүлж ирсэн нь Интерьер дизайн хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний онцлогт тохиромжтой байна.

Анхаарах асуудал:

Орчин үеийн технологийн дэвшилттэй уялдуулах, танхимын ба цахим арга зүйн хосолсон хувилбарыг хөтөлбөр хэрэгжүүлэх орчинтойгоо уялдуулсан байх боломжийг судлах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Дизайны бусад чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулах, нийгмийн хөгжлийн хурд, эдийн засаг, хүрээлэн буй орчин болон хүмүүсийн эрэлт хэрэгцээ, орчин үеийн технологийн дэвшилтэд хөтөлбөр нь хэрхэн холбогдож байгааг судлах,

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо: ШУТИС 2030 стратеги төлөвлөлт, Алсын хараа: “дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ”, эрхэм зорилготой уялдуулан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан.
- ✓ Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо оролцогч талуудаар хэлэлцүүлж саналыг тусгадаг

Онцлог зүйл: Интерьер дизайн хөтөлбөрийн үр дүн нь элсэгчийн дизайн сэтгэлгээ, зохион бүтээх авьяасад тулгуурлан гардгаараа онцлогтой

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлдэг байх;
- ✓ Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг зураглан, тодорхойлох;
- ✓ Хөтөлбөрийн боловсролын зорилго (PEOs) -шинэчлэн нарийвчлан сайжруулах;

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж: Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;

Шаардлага: Хөтөлбөрийн зорилго (PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs) хичээлийн хүрэх үр дүн (CLOs)-г боловсруулахдаа хамт олноор хэлэлцүүлж, ойлголтоо цэгцлэх хэлэлцүүлгийн үр дүнд гарсан шийдвэрийг хөтөлбөртөө тусгадаг тухай нотлох баримтыг бүрдүүлдэг байх;

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Нийт 5 удаа, Интерьер дизайн нэршлээр сургалтын төлөвлөгөөг 3 дахь удаагийн шинэчлэл хийгдэж байгаа
- ✓ 2022 оны 05 сарын 09-ний өдрийн А/160 тоот тушаалыг баримталж сургалтын хөтөлбөрийн индекс, ангиллыг шинэчилсэн ба тавигдах шаардлагыг биелүүлсэн
- ✓ Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бүх хичээлүүд нь батлагдсан хичээлийн стандарт хөтөлбөрүүдтэй.
- ✓ Хичээлийн стандарт хөтөлбөр нь хичээлийн зорилго, хүрэх үр дүн, лекц, дадлага, бие даалтын товч агуулга, хичээлийн удирдамж, оюутны гүйцэтгэлийг үнэлэх арга хэлбэрийг тодорхойлсон.
- ✓ Суралцагчид нь сургалтын нэгдсэн төлөвлөгөөгөөр нийт 128 кредит цаг судлах, 2 удаагийн 2 кредит цагийн дадлага хийдэг байна.
- ✓ 200 кодтой сонгон хичээлийг нэмсэн

Онцлог зүйл: Оюутны гүйцэтгэлийг үнэлэх арга хэлбэрийг CDIO арга зүйн олон хувилбараар тодорхойлж, аргачлалыг тусгасан.

Анхаарах асуудал: Хичээлийн суралцахуйн үр дүнг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулсан матрицыг нягтлах;

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Интерьер дизайны асуудал нь өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлага, шинэ зохиомжийн материалын нөлөөнөөс үүдэлтэй техник технологийн шинэчлэл явагдаж байдаг үзэгдэлтэй нийцүүлэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, төгсөгчийн цогц чадамжийг дахин шинэчлэн боловсруулах

ШАЛГУУР 1.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Интерьер дизайн хөтөлбөрөөр судлах хичээл хоорондын уялдаа холбоог гаргасан, хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлын матриц хийсэн.
- ✓ Суралцагч нь удирдлагын мэдээллийн системээр дамжуулан ерөнхий суурь, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдээс багц цаг нэмж сонгон судлах боломжтой.
- ✓ Хичээл бүрийн стандарт төлөвлөгөөг батлуулсан бөгөөд хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон,
- ✓ Сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг.
- ✓ Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнгийн дагуу хичээл хоорондын залгамж холбоог тодорхойлж, сургалтын технологийн залгамж холбоог хангахад чиглэн явуулдаг.
- ✓ Суралцагчийн цагийн ачааллыг тооцоолдог, оюутны нэг улирлын ачаалал 21 кредитээс хэтрэхгүй байна.

Онцлог зүйл: Суралцагчийн хүсэлтээр орон нутгийн байгууллагад ажлын байрны удирдагчийн өгсөн удирдамжийн дагуу хийх боломжийг олгодог ба тус сургуулиас томилогдсон мэргэжлийн багш зөвлөмжөөр тусалдаг

Анхаарах асуудал: Суралцагчдад сургалтын орчноос шалтгаалсан хүндрэлтэй байдал, хичээл сонголтын танилцуулга сурталчилгаа дутуу хийгддэгээс хамааралтай бэрхшээлүүд нэлээд үүсдэг тул тохижилт, техникийн шинэчлэлтэй холбоотой сургалтын зохион байгуулалтын асуудлыг хэсэгчлэн бага багаар шийдвэрлэх

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж: Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримт бичигт тусгаж тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;

Шаардлага:

- ✓ Сургалтын хөтөлбөрийн агуулга, төлөвлөлтөд сайжруулалтыг хийх, хэвлэх
- ✓ Суралцагчдын хэлэлцүүлгээс гарсан практик ур чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулгыг (архитектурын хийц, 3D ухаалаг техник, гүйцэтгэх технологийн практик, инженерийн тооцоолол гэх мэт) нэмэх бололцоог судлан, хөтөлбөрөө сайжруулах;

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Суралцагчид хичээл болон багш, суралцах улирлыг сонгох давуу байдлыг бүрдүүлсэн
- ✓ Сургалтыг хөтлөн явуулахдаа оюутан төвтэй, төслийн арга зүйд тулгуурлан, тэдний оролцоог дэмжсэн үйлээр дамжуулан сургах идэвхтэй сургалтын арга зүйг ашигладаг.
- ✓ Багш нарын сургалтын арга зүйд өгсөн суралцагчийн үнэлгээний үр дүнд дүн, шинжилгээг сургалтын албанаас зохион байгуулдаг. Үнэлгээний тайланг багшийн аттестатчилалд хэрэглэдэг.

Онцлог зүйл: Сургалтаа CDIO арга зүйгээр хөтлөн явуулдаг

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрт ашиглаж байгаа сургалтын арга зүйд дүн шинжилгээ хийх;
- ✓ Хичээлийн суралцахуйн үр дүнд өгсөн оюутны сэтгэл ханамжийн мэдээллийг багш бүрд хүргэж, дүгнэлт хийлгэдэг байх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Хөтөлбөрийн хувьд сурган заах арга, суралцахуйн үнэлгээ нь хоорондоо харилцан уялдаатай байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэлх сургалтын болон үнэлгээний арга хэлбэрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Багш нар оюутны мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэхдээ ШУТС-ийн үнэлгээний нэгсэн системийг ашигладаг (6 хэсэгтэй)
- ✓ ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан нэгдсэн үнэлгээний журмыг баримтлан ажилладаг
- ✓ Багшийн болон оюутны программтай
- ✓ Төгсөлтийн шалгалтын материалд тогтмол үнэлгээ хийдэг

Онцлог зүйл: Суралцагчдын бүтээлийн үнэлгээ гаргахдаа нэгдсэн байдлаар просматор, үзэсгэлэн гаргаж дүгнэдэг нь харилцан суралцах, шилдгийг шалгаруулан дотоод гадаадын уралдаан тэмцээн оролцуулдаг нь сайшаалтай

Анхаарах асуудал: Хичээлийн үнэлгээнд суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэл талаас нь дүн шинжилгээ хийж, хэрхэн сайжруулах талаар санал зөвлөмж гарган хэрэгжүүлдэг байх;

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Интерьер дизайн мэргэжлийн хөтөлбөрийн хувьд хичээлийн үнэлгээ, арга зүйг сайжруулах чиглэлээр зөвхөн мэргэжлийн тэнхимийн багш төдий биш бусад тэнхимээс тухайн хөтөлбөрт оролцдог багшийн хичээл, түүний үнэлгээ, арга зүйд анхаарч хөтөлбөр төвтэй ажиллах.

ШАЛГУУР 2.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Интерьер дизайн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг үндсэн лаборатори, урлангууд нь 48,280,300 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон байдаг. CAD-CAM компьютерын лаборатори 32 м², 2018 оны 09-р сард байгуулж, сургалтад ашиглаж эхэлсэн. Нийт 38,743,500 төгрөгийн үнэ бүхий өртөгтэй лаборатори юм. Интерьерийн урлан нь дизайны салбар үүссэн цагаас байгуулагдсан бөгөөд 2008 онд ШУТИС-ийн ТНС-гийн байранд шилжсэн.
- ✓ ШУТИС-ийн ҮТС-ийн удирдлага хамт олон сүүлийн найман жилийн турш Үйлдвэрлэлийн технологи, дизайн, судалгаа инновацын төв байгуулахаар ажиллаж байна. Шинэ инновацын төвд судалгааны 8 лаборатори, лекцийн 8 тэнхим, урлан семинарын 11 танхим, спортын заал, усан бассейн, фитнесийн танхим, бие даан суралцах орчин, номын сан, хурал семинарын танхимуудыг төлөвлөсөн. Тус барилгын зориулалтаар 2015 онд Нийслэлийн засаг дарга 3208 м² талбай бүхий газар олгосон. Одоогоор бичиг баримтуудыг бүрдүүлж, барилгын зураг төсөл, ТЭЗҮ-г хийлгээд байна.
- ✓ “COVID-19” халдварт цар тахлын үеэс сургалтдаа ШУТИС-ийн цахим сургалтын “UNILMS” (Learning Management System) системийг ашиглахын сацуу Microsoft Teams программыг нэвтрүүлснээр “Интерьер дизайн” хөтөлбөрийн бүх хичээл бүрэн цахим хэлбэрт шилжсэн.
- ✓ Интерьер дизайн хөтөлбөрийн багш суралцагчид ШУТИС-ийн Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан, ҮТС-ийн гэсэн нийт хоёр номын сангаар үйлчлүүлдэг. ШУТИС-ийн төв номын сан нь 7000м² талбайтай, 900 суудал

бүхий үйлчилгээний 20 гаруй нэгжээр үйлчилгээ үзүүлдэг. Тус номын сангийн электрон катологид 350000 гаруй номын бүртгэлтэй.

- ✓ ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургуулийн Номын сан 60 суудалтай. Номын сан хөмрөгийн 50% орос, 40% монгол, 7% англи, 3% нь бусад хэлээр байдаг. Номын сангийн фондод интерьер дизайн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйд нийцсэн 303 нэр төрлийн 628 ширхэг 11,783,540 төгрөгийн үнэ бүхий номтой.
- ✓ ШУТИС-ийн “Эрүүл мэндийн төв”-ийн ажиллах дотоод журам. ШУТИС-ийн Ректорын 2012 оны 4-р сарын 11-ны өдрийн А/64 тоот тушаалын нэгдүгээр хавсралт. ШУТИС-ийн вэб https://www.must.edu.mn/mn/must_emt_juram/
- ✓ “ШУТИС-ийн Музейн үйл ажиллагааг зохицуулах журам. ШУТИС-ийн захирлын 2021 оны 09 сарын 30-ний өдрийн А/174 тоот тушаалын хавсралт. ШУТИС-ийн вэб https://www.must.edu.mn/media/uploads/2021/10/06/km_226_01718.pdf

Онцлог зүйл:

- ✓ Үйлдвэрлэлийн технологи, дизайн, судалгаа инновацын төв байгуулахаар ажиллаж байна.
- ✓ “Интерьер дизайн” хөтөлбөрийн бүх хичээл бүрэн цахим хэлбэрт шилжсэн.
- ✓ “24 цагийн уншлагын танхим”-тай. Уншлагын танхим нь ШУТИС-ийн Шинжлэх Ухаан, Технологийн төв номын сангийн барилгад байрладаг.
- ✓ ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвтэй. Тус төв нь нийт профессор багш, оюутнууд, ажилтан албан хаагчдад үйлчлэн ажиллаж байна. Хэлбэр судлалын дадлагад эмч дагалдаж явдаг.
- ✓ ШУТИС-ийн Музей нь албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр.
- ✓ Интерьер дизайн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд 2-р курст хэлбэр судлалын дадлагыг Горхи-Тэрэлж дэх ШУТИС-ийн полигон дээр 10 хоногийн турш хийдэг.
- ✓ Олон Улсын Эрдэм шинжилгээний хурлын их танхимтай.

Анхаарах асуудал:

- ✓ Суралцагчдын тоо өсөн нэмэгдэж байгаатай холбоотой оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх орчин бүрдүүлсэн анги танхимын хүрэлцээ тааруу байна.
- ✓ Интерьер дизайн мэргэжлийн хичээлүүдийг ШУТИС-ийн хичээлийн 4-р байранд сургалтыг явуулж байна. Одоогийн сургалтын орчин, барилгын үйл ажиллагааны зориулалтгүй байдал, ашиглалтын хугацаатай холбоотой элсэгчдээ алдах магадлалтай.
- ✓ Баримал керамикийн урлангийн сургалтын үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэж агаар сэлгэлтийн системийн ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- ✓ Оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх орчин бүрдүүлсэн анги танхимыг нэмэгдүүлэх. Баримал керамикийн урлангийн агаар сэлгэлтийг сайжруулах.

- ✓ Үйлдвэрлэлийн технологи, дизайн, судалгаа инновацын төв байгуулах ажлыг эрчимжүүлэх.

Шаардлага:

- ✓ Оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх орчин, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан зориулалтын ширээ, сандал, багш, оюутны компьютерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэвлэлийн техник тоноглолоор бүрдүүлсэн анги танхимын хүртээмжийг нэмэгдүүлэх, баримал керамикийн урлангийн агаар сэлгэлтийг сайжруулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Тайлантай холбоотой нотлох баримтуудтай танилцаж, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авсан.
- ✓ Багш, оюутнуудтай танхимаар уулзалт, ярилцлага хийж, төгсөгчид, ажил олгогчтой хийх уулзалтыг цахимаар холбогдож санал бодлыг солилцлоо.

Онцлог зүйл:

- ✓ Хичээл практикийн зарим зардлыг сургуулиас олгодог.
- ✓ “Оюутны гарын авлага” дахь мэдээллийг оюутны вэб-д тавьдаг болсон нь хүртээмжийг сайжруулсан ахиц болсон.

Анхаарах асуудал:

- ✓ Сургалтад ашиглагдаж байгаа лабораторийн компьютерын хүчин чадлын үзүүлэлтээс харахад процессорууд нь интерьер дизайны мэргэжлийн программуудыг ажиллуулахад хангалттай бус байна.
- ✓ Нэг оюутанд ноогдох суурин ба зөөврийн компьютерын хүрэлцээ хангалтгүй.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- ✓ Интерьер дизайн хөтөлбөрийн программ хангамжийн хэрэгцээ шаардлага жилээс жилд шинэчлэгдэж байгаатай уялдуулан одоо байгаа лабораторийн тоног төхөөрөмж, хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх.
- ✓ Үйлдвэрлэлийн дизайны материал судлал хичээлийн сургалтын үзүүлэн материалыг бүрдүүлэх.
- ✓ Төгсөгч, ажил олгогчдоос гарсан санал болох барилга инженерчлэл, ажлын зураг унших, техник хэрэгсэлтэй харьцах чадварыг хөгжүүлэх чиглэлийг сургалтын төлөвлөгөөндөө оруулж өгөх.

Шаардлага:

Одоо байгаа лабораторийн компьютерын тоо, хүчин чадлыг программ хангамжийн хэрэгцээ шаардлага уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Шинжлэх Ухаан, Технологийн төв номын сан: <http://library.must.edu.mn/>. ШУТИС-ийн Номын сангийн электрон каталог: <https://lib4u.online/?lib=must>
- ✓ ШУТИС-ийн Шинжлэх ухаан, технологийн номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулсан. 2015 оны 01 сарын 15 өдөр Дугаар А/38 тоот тушаалын хавсралт.
- ✓ ШУТИС-ийн процессор багш нарын ном, сурах бичиг, сургалтын материал бичиж, хэвлүүлэхэд баримтлах журам боловсруулсан. 2018 оны 03 сарын 27 өдөр А/55 тоот тушаалын хавсралт.
- ✓ Үйлдвэрлэлийн технологийн номын сан: <http://www.sitech.edu.mn/mn/page/25> Номын сангийн электрон каталог нь <http://catalog.must.edu.mn/> хаягаар интернэтэд байрладаг бөгөөд ямар ч суралцагч, хаанаас орж номын хайлт хийх боломжтой.

Онцлог зүйл:

- ✓ ШУТИС Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан Монголд анх удаа цахим номын санг бий болгох гэж зорьж байна.
- ✓ 24 цагийн уншлагын танхимтай.
- ✓ ШУТИС-ийн Хурлын танхим /604/. Суудлын тоо: 140, Тайлбай хэмжээ: 190м2, Зориулалт: Гадаад, дотоод эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн явуулах.
- ✓ ШУТИС-ийн Тогтмол хэвлэлийн уншлагын танхим /504/. Суудлын тоо: 30, Тайлбай хэмжээ: 110м2, Зориулалт: Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт явуулах.
- ✓ Эрдэм шинжилгээний уншлагын танхим /602/. Суудлын тоо: 50, Тайлбай хэмжээ: 176м2, Зориулалт: Хурал, зөвлөгөөн, сургалт явуулах.
- ✓ ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний фонд: Уулзалтын танхим /201 А/. Суудлын тоо: 4, Зориулалт: Уулзалт, багаар ажиллах. /201 В/. Суудлын тоо: 4, Зориулалт: Уулзалт, багаар ажиллах. /201 С/. Суудлын тоо: 10, Зориулалт: Уулзалт, багаар ажиллах.

Анхаарах асуудал: Оюутнуудаас гарсан саналын дагуу номын сангууд хуваарийн дагуу ажиллаж байгаа хэдий ч тухайн мэргэжлийн онцлогт тохирсон ашиглах талбай бүхий ширээтэй номын сангийн орчныг бий болгох тал дээр анхаарах;

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ✓ Нийгмийн хөгжлийг дагаад байнга өөрчлөгдөх буй интерьер дизайны сургалтад ашиглаж буй ном, гарын авлагын хэвлэгдсэн он буюу сүүлийн хувилбар мөн эсэхэд анхаарч, цахим хэрэглээг нэмэгдүүлэх;
- ✓ Интерьер дизайны хөтөлбөр нь Монгол улсын хэмжээнд шинэ, цөөн байгаа тул ном сурах бичгийн тал дээр сайжруулах шаардлага гарсаар байгаа, иймээс сургалтын хөтөлбөр, агуулгатай уялдуулж ном сурах бичгийн санг шинэчлэх;

ШАЛГУУР 3.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Хэсэгчлэн хангасан

ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Интерьер дизайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Дизайны салбар бөгөөд хөтөлбөрийг боловсруулах, батлуулах явц нь дээд боловсролын хуулийн дагуу сургуулийн зөвлөл, эрдмийн зөвлөлийн хяналтын дор хэрэгжүүлдэг.
- ✓ ШУТИС-ийн захирлын тушаал-Хөтөлбөрийн ерөнхий хорооны журам 2023.05.24-ны өдрийн А/173/ тогтоол-хөтөлбөрийн удирдлага, сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн.
- ✓ Хөтөлбөрийн дэд хороо хөтөлбөрийн шинэчлэлийн талаар 2019, 2021, 2023 онуудад 3 удаа хуралдаж /протоколтой/ сургалтын чиглэлээр 3, судалгааны чиглэлээр 4 асуудлыг шийдсэн байна.
- ✓ Сургалтын үйл ажиллагааг зохицуулах 30 орчим дүрэм, журамтай.
- ✓ “ШУТИС-ийн 2020-2030 мастер төлөвлөгөө” урт хугацааны төлөвлөгөөтэй, бүрэлдэхүүн сургуулиуд мөрдөж ажилладаг.

Онцлог зүйл:

- ✓ “ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал 2012-2021”, “ШУТИС-ийн 2021 он мастер төлөвлөгөө”, “ШУТИС-ийн 2020-2023 он мастер төлөвлөгөө” зэрэг урт хугацааны төлөвлөгөөнүүдийг хамт олноор хэлэлцүүлэн ШУТИС-ийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон хөгжлийн стратегийн зорилго зорилтууд, хэрэгжүүлэх үе шатуудыг тодорхойлон ажилладаг.
- ✓ UNIMIS удирдлагын мэдээллийн системийг ашиглан оюутан өөрийн суралцаж буй хөтөлбөр, хичээлүүд, төлбөрийн мэдээлэл болон багш сонголт, суралцсан хугацааны үнэлгээ, улирлын эцэст сургалтын агуулга болон багшийг үнэлэх, эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлийн явцыг хянах боломжоор хангагдсан.
- ✓ Багш нарын хувьд хичээлийн хуваарь, хичээлийн агуулга, бүртгэл, оноо зэргийг UNIMIS удирдлагын мэдээллийн системээр дамжуулан хүргэдэг.
- ✓ Хөтөлбөрийн хувьд оюутан, багш, сургалтын үйл ажиллагааны бүхий л үйл явцыг REALTIME буюу тасралтгүйгээр үргэлжлүүлэх боломжоор хангагдсан тул мэдээллийг шуурхай дамжуулдаг.
- ✓ ШУТИС-ийн хэмжээнд гарч буй шийдвэр өөрчлөлтүүд болон ҮТС-ийн захиргаа, салбараас гарсан шийдвэр, хөтөлбөрийн зорилго зорилтууд, үйл ажиллагааны үр дүнгийн талаар сургуулийн удирдлагын зүгээс нэгдсэн мэдээллийг дамжуулахдаа багшийн ШУТИС-ийн веб хуудсаар /www.must.edu.mn/ болон

оюутны /www. Sitech.edu.mn/ веб хуудсанд тавьж мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийдэг.

- ✓ Сургуулийн хэмжээгээр оролцогч болон сонирхогч талуудын санал гомдлыг
 - Өргөдөл, хүсэлтээр
 - Биечлэн ирж уулзах
 - Сэтгэл ханамжийн судалгаагаар
 - Интернэтээр /e-mail/ зэрэг хэлбэрүүдээр хүлээн авч холбогдох албатууд шийдвэрлэдэг тогтсон системтэй.
 - Сургалт судалгааны ажилтай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хөтөлбөрийн багш нар, хөтөлбөр хариуцсан дэд профессор, салбарын хурал, оюутны клубээр хэлэлцэж санал санаачилга, санал хүсэлтийг дэмжиж ажилладаг.

Анхаарах асуудал:

Хөтөлбөрийн хувьд тогтвортой байдлын шинжилгээ болон стратегийн төлөвлөлтийг гаргаж ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайланг сайтар төлөвлөдөг байх
- Хөтөлбөрийг сайжруулах, удирдах чиглэлд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар үйлдвэр, аж ахуйн газруудтай бүтээгдэхүүний чанар, хийцийг шинэчлэх, сайжруулах бүтээгдэхүүний стандарт, техникийн бичиг баримтуудыг боловсруулах, шинэ загвар гаргахад хамтран ажилладаг /Хүснэгт 4.1/, Олон улсад өрсөлдөх, чадавхыг өсгөхөд чиглэсэн цогц судалгаа, бодлогын зөвлөмж боловсруулах төсөл /52 сая/, Ойрад Монголчууд, Оросын Халимгуудын ардын дүрслэл чимэглэх урлаг харьцуулсан судалгаа /36 сая/, ОХУ-ын Хакатонд шүүгчээр ажилласан байна.
- ✓ Төслийн болон гэрээт ажлын 10 хувийг сургуульд орлого болгож хичээл практикийн зардал, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэн хөгжүүлэхэд тусгадаг байна.
- ✓ Төсөл хөтөлбөрт хамрагдсанаар мэргэжлийн ур чадвар мэдлэг туршлага нэмэгддэг, хөтөлбөрийн хөгжил шинэчлэлд зааж буй хичээлийн агуулгад олж авсан мэдлэг, туршлагад үндэслэн сайжруулалт хийх, хамт олонд мэдлэг мэдээлэл дамжуулах, гадаад дотоодын харилцаа холбоо сайжирснаар оюутны дадлага, ЭШХ-дад илтгэл хэлэлцүүлэх, мэргэжлийн уралдаан тэмцээнд оюутнуудын оролцоог нэмэгдүүлдэг байна.

Онцлог зүйл:

- ✓ Багш, суралцагч, солилцооны зохион байгуулалт, хэрэгжилтийн хувьд жил бүр 20-30 багш судлаач, магистрантур, докторантурын сургалтад хамрагддаг.
- ✓ ШУТИС нь ХБНГУ, Япон, БНСУ, БНХАУ зэрэг 21 орны 130 гаруй их дээд сургуультай хамтын ажиллагаатай ажилладаг бөгөөд бакалаврын 2+2, магистрын 1+1 хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.
- ✓ Жилд 20-30 гадаад оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан байна.
- Хөтөлбөрийн чанараа сайжруулах, төгсөгчдийн ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор Монголын дизайнеруудын холбоо, Үйлдвэрлэлийн дизайнеруудын холбоо зэрэг мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж нийгэмд үйлчилгээ үзүүлэх, хөтөлбөрийг шинэчлэх хүрээнд мэдээлэл солилцох, туршлага судлах мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулах, уралдаан тэмцээн, ЭШХ-д багш оюутнуудаа оролцуулах зэргээр хамтран ажилладаг.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээ тогтмолжин ААН-үдэд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг, төсөл хөтөлбөр дээр хамтран ажиллах, гэрээт ажлууд болон оюутны дадлага зохион байгуулах, мэдээлэл солилцох, туршлага судлах зэргээр хамтарч ажилладаг.
- ✓ Интерьер дизайн хөтөлбөрийн төгсөгч оюутнууд “ШУТИС-ийн төгсөгчдийн холбоо” болон “ШУТИС Үйлдвэрлэлийн дизайн мэргэжлийн төгсөгчид” зэрэг FB хаягаар дамжуулан туршлага хуваалцах, мэргэжлийн чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэх, ажлын байрны зар түгээх зэргээр хамтран ажиллаж, 2021-2022 онуудад “Дизайн Виталити” наадмын хүрээнд дугуй ширээний уулзалт хийж цаашид уламжлал болгон зохион байгуулсан.

Анхаарах асуудал:

Төгсөгчдийн холбоог байгуулан ажиллах, эргэх холбоог сайжруулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Интерьер дизайн хөтөлбөрийн төгсөгчдийг богино хэмжээний сургалтад хамруулах, төгсөгчдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төгсөгчдийн холбоог байгуулан эргэх холбоог сайжруулах зохион байгуулах ажил дутмаг байна. Богино хугацааны сургалтыг төлөвлөх, хөтөлбөр гарган ажиллах боломжтой

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Нийт орлогын бүтэц нь сургалтын төлбөрийн орлого 40 хувь, Эрдэм шинжилгээний орлого 4 хувь, Бусад орлого 18 хувь, Төсвөөс санхүүжих 1 хувь, сургууль хоорондын 37 хувийг тус тус эзэлсэн байна.
- ✓ Зардлын шинжилгээний хувьд нийт зардлын 49 хувийг сургууль хоорондын зардал, сургалтын үйл ажиллагааны зардалд 33 хувь, Шууд бус зардалд 3 хувь, ЭШ, инновацийн үйл ажиллагаанд 4 хувь, оюутны үйлчилгээний зардалд 0,27 хувь тус тус зарцуулсан байна.

- ✓ Сургалттай холбоотой шууд зардал багшийг дэмжих 0,2 хувь, хичээл практик 2,9 хувь, ном хэвлэлд 1,1 хувь, хөтөлбөрийн МИ 1,4 хувь, тогтмол зардал 4,1 хувь мэдээлэл сурталчилгаа 0,1 хувь мэдээллийн технологийн зардал 0,1 хувь, цалин шимтгэл 91,6 хувийг эзэлдэг.
- ✓ Сургалттай холбоотой шууд зардал өмнөх оноос 2,3 хувиар, буюу 53,8 сая.төгрөгөөр өсч, батлагдсан төсвөөс 25,8 хувь буюу 844,6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Онцлог зүйл:

- ✓ ҮТС нь тухайн жилийн төсвөө санхүүгийн албатай хамтран урьдчилан гарган захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ШУТИС-ийн Эдийн Засаг, хөгжлийн проректороор батлуулан дагаж мөрддөг.
- ✓ Сургуулийн сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулан жил бүрийн төсөвт шаардлагатай зардлын хэмжээг тусгаж өгдөг.
- ✓ Сургуулийн орлого, зарлагыг төлөвлөхөд салбарын эрхлэгч, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багийн тэргүүлэх профессорууд хамтран оролцдог.
- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг тухайн жилийн инфляци, суралцагчдын тоо, багш ажилтны тоо, зардлын үзүүлэлтүүдийг зүйл бүрээр тооцон ШУТИС-ийн хэмжээнд нэгтгэн БШУЯ, СЯ-аар хянуулж /Хүснэгт4,5/ баталгаажуулдаг.
- ✓ Санхүүгийн үйл ажиллагааг хянах зорилгоор санхүүгийн тайландаа шинжилгээ хийдэг. Тухайлбал, өөрийн хөрөнгийн оролцоо, ажлын капитал болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа зэрэг үзүүлэлтээр шинжилгээ хийж дүгнэлт өгдөг.
- ✓ Сургалтын төлбөрийг 100 хувь хөтөлбөрт зарцуулдаг.
- ✓ Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг дараах байдлаар зарцуулдаг. Үүнд:
 - Багш нарын мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх
 - Улирал бүр мэргэжлийн хичээлд оюутнуудад зориулан шаардагдах материал авах сургалтын зардал
 - Багш нарыг мэргэжил дээшлэх сургалтад хамруулах
 - Багш нарын ажиллах нөхцөлийг сайжруулах
 - ЭШХ, бүтээлийн уралдаан үзэсгэлэн, спорт урлагийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг.

Анхаарах асуудал:

Хичээлийн байрыг шинэчлэн сайжруулах шаардлагатай.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Шинэ хичээлийн байртай болбол талбайн ашиглалт нэмэгдэж, төсөл хөтөлбөрт хамрагдах, орлогоо нэмэгдүүлэх боломжтой юм.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- ✓ Хичээлийн жилийн эхэнд “Төгсөгчдийн мөшгөх судалгаа”-г төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нөхцөл зэргийг санал асуулгаар судлан жил бүр явуулдаг.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- ✓ Хөтөлбөрийн баг хэвлэл мэдээлэл, радио телевизийн сурталчилгаа, сургууль, салбарын үзэсгэлэн, техник, технологийн уралдаан тэмцээн, салбарын хэмжээний хурал, зөвлөгөөн, семинарын хүрээнд сурталчилгаа явуулдаг.
- ✓ “Алтан хулгана”, “Торгон зам”, “Design Vitality”, наадмууд жил бүр зохион байгуулдаг бөгөөд ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудыг хамруулан зохион байгуулдаг.
- ✓ Хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг
 - Сургуулийн вэб хуудас
 - Боловсролын үзэсгэлэн яармагт оролцох
 - Танилцуулга материал хэвлэж тараах
 - Телевиз радиогоор сургууль, хөтөлбөрийг сурталчлах, мэдээлэл түгээх
 - Элсэгч, төгсөгч нарт зориулан “ШУТИС-Бидний бахархал” өдөрлөг сургалт
 - Багш оюутны үзэсгэлэн гаргах
 - ЕБС-ын сурагчдад танилцуулга хийх
 - ЕБС-ийн сурагчдын дунд 1 өдрийн сургалт зохион байгуулах
 - “Хөнгөн аж үйлдвэр” сэтгүүл зэрэг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан элсэгчдийн дунд идэвхжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг арга, хэлбэрүүдээр хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг хийдэг.

Анхаарах асуудал: Хамтран ажилладаг байгууллага, мэргэжлийн холбоодоор дамжуулан хөтөлбөрөө сурталчлах, хөтөлбөрт сайжруулалт хийх талаар санал, зөвлөмжийг тусгаж байхад анхаарах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ✓ Интерьер дизайн хөтөлбөр, мэргэжлийн ач холбогдол, давуу талыг олон нийтэд сурталчлан таниулах талаар мэргэжлийн багш, тэнхим, төгсөгчдийн оролцоог нэмэгдүүлэх талаар хийсэн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэдэг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөж ажилладаг байх;
- ✓ Хөтөлбөрийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн технологийн хөгжлийн ололтыг ашиглах бодлого баримтлах.

